

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

|   |                                    |                     |                   |
|---|------------------------------------|---------------------|-------------------|
| Ярилцлага өгөгчийн нэр                              | Самдангийн Гончиг                  | Дугаар              | L018              |
| Оршин суугаа аймаг                                  | Улаанбаатар хот                    | Оршин суугаа сум    | Баянгол дүүрэг    |
| Төрсөн газар  | Завхан аймгийн Цэцэн-Уул сум       | Төрсөн он           | 1909              |
| Ажил мэргэжил                                       | Лам                                |                     |                   |
| Лам байсан эсэх,<br>Шавилан сууж байсан<br>сүм хийд | Тэгшийн хүрээ,<br>Дашчоймбэл дацан | Сүм хийдийн дугаар  | ЗАЦУ 033, UBR 912 |
| Одоогийн сүм хийд                                   | Дашчоймбэл                         | Сүм хийдийн дугаар  | UB 014            |
| Ярилцлага авсан он<br>сар өдөр                      | 2007 оны 12-р сарын 16             | Ярилцлага авсан хүн | Ч. Хулан          |



Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Тэгшийн хүрээ, Их хүрээний Дашчоймбэл дацан

Би анх Тэгшийн хүрээнд сууж байсан. Тэгшийн хүрээ Завхан аймгийн Цэцэн-Уул сумынх. 700-800 ламтай. Чойр, цогчэн, жүд, дүйнхор, ганжуур, ламрин дацантай байсан. Би 8,9 тэй эхэлж хураад 17,18 тай энд ирсэн. Чойрт хурдаг байсан. Дом тавихын өмнөх жил энд ирсэн. Тэгшийн хүрээний төвд нэрийг Норовдигваалин гэдэг байсан. Энд ирээд би Дашчоймбэлд хурсан .Хаагдахад нь хэдэн жил завсарласан. Жаал жуухан ажил хийгээд л явж байсан. Тэгээд Ганданд хурсан. Дараа нь Дашчоймбэлд хурж эхэлсэн.

Тэгшийн хүрээ нь Хорол цорж ламын хийд. 5 билүү 6 дахь дүр нь байх. Хорол цорж гэдэг нь 5-р дүр. Номч лам урагшаа явж лхаарамба болж байсан том гэгээн. Энэтхэгт морилж байсан. Гол шүтээн дацангийнх нь Гомбо шүтээн. Жинхэнэ том нь Лхам сахиус байсан. Гол ядам нь ядмуудыг дор

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дор нь хэлээд хурдаг. Ядам цорж гэдгийн, Ядам нь Ямандаг юм. Дамдинчойжоо гэдэг сахиустай айл /хүрээ/ байсан. Чойр дацангийнх Гомбо. Цогчэнгийнх Лхам, Ямандагаар ядамладаг. Сэра игчаатай бол Дамдин янсан. Гол сахиус Гомбо Дүйнхор. 1000 бурханы дуган гэж байсан. Цутгамал гуулин бурханууд байсан.

Манай нутаг хурлын газар их байгаагүй. Тариатын хурал, мөн Олон булагийн хурал, Холбоогийн хурал, Сантад баргын хурал гэж нэг, Хужиртын, Сонгино сумын Нарангийн хурал гэсэн жижиг хурлын газрууд байсан.

1937 оны 9-р сарын 22-нд Хүрээний ихэсүүдийг шийтгэсэн. Хорь гаруй хүн байсан. Хамба лам гээд дандаа томчуул байсан. Би нэг өдөр л төв театрт очиж харсан.

Тэгшийн хүрээнд Баян унзад гэдэг хүн байсан. Урд явж байсан. Тэгээд урд явж байсан гэж Завхан дээр гурван жил шоронд орсон юм. Тэр их том унзад. Тэгээд хүрээн дээрээ эргэж ирээд гавж болоод. Сүүлд нь баригдсан л гэсэн. Тэрнээс хойшихыг нь мэдэхгүй. Баян унзад гэж байсан. Цэнджав унзад таалал төгссөн. Дагва гэдэг унзад байсан. Мижид гуай гэдэг унзад байсан. Тэгшийн хүрээнд тэр нутгийн хүмүүс л шавилан сууна. Тэгшийн хүрээнд Зундуй гэж нэг зураач лам байсан. Дорлиг гэдэг том маарамба байсан. Тэгээд сайн улс их бий. Манайхны сайн улсууд голдуу Дашчоймбэлд хурж байсан юм. Тэгшийн хүрээний хамба лам нь миний багш Доржбал гэж байсан. Цорж лам нь Лут гуай л байсан бол уу, Сүрэндорж ловон гэдэг хүн байсан бодогдоод байна. Жижигхэн хүн байсан. Дандаа томчуул. Гэсгүй нь Санж гэдэг лам байсан. Дэлбээн Дорлиг гэдэг хүн даамал нь, нярав нь Чогсом гэдэг хүн байсан. Олон газрууд тус тусдаа нярав, даамалтай.

Би Чойр дацанд хурж байсан. Манай зиндаанд 24 лам байсан. Одоо тэд нараас ганц ч байхгүй. Миний хурж байсан Дашчоймбэл дацан 6000 гаран ламтай байсан. Манай зиндаанаас одоо надтай хоёрхон хүн үлдээд байна. Тэгшийн хүрээнд 7, 8 суврага байсан. Тусдаа байшинтай. Одоо бodoход Бурханы найман чод дэн л юм. Хийдэд ном барлах үйлдвэр байсан. Чойрын ном, зүгээр судар, чого зэргийг барлана. Тэр нь тийм ихгүй. Манай багш их эрдэмтэй хүн байсан. Тэр хүн ном зохиогоогүй. Яагаад тэгсэн гэхээр болохгүй байна гэдэг байсан гэсэн.

Чойр дацанд хурдаг байсан. Гүнрэг хурдаг байсан. Гүнрэгийн тусдаа дуган байсан. Ганжуурын том сүм байсан. Хайлантай байсан. 100 гаран гэлэн гэцэл байсан байх. Хайланг том дугандаа мөн лам нар цөөхөн байвал Майдарын дуганд хурдаг байсан байх. Том дуган дүүрдэг л байсан. Нэг их том цам гардаггүй байсан. Дүйнхорын цам гардаг байсан. Цам зуны адаг сарын шинийн дөрвөнд гардаг байсан. Би тэрэнд мөн явж л байсан. Арваад хоногийн өмнөөс дэг хийж бэлдэнэ. Тэгээд нэг л өдөр үргэлжилнэ. Цамд 50-иад дүр гардаг байж. Майдар эргэнэ. Хавар нэг л өдөр эргэнэ. Ганжуур ган зуд болвол арваад тэмээ аччихаад шүтээнээ залаад хошуугаа эргэнэ. Урд Галуутайн хийд дээр намрын дунд сарын 15 нд гардаг байсан. Тэгэхээр тэр Ганжуураа залаад тэнд уншдаг байсан гэсэн. Манай гэгээн манай хошууны хамгийн анхны Ганжуурыг залсан. Тиймээс аваачиж байгаа юм гэдэг. Хурчаад л аваад ирнэ. Арваад тэмээтэй, дандаа булагиаран авдартай, дээгүүр нь улаан юмаар бүтээчихсэн байдаг байсан. Гавжийн дамжаа зунд нэг сууна. Жүдэд аграмбын дамжаа гэж сууна.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвөл домын дамжаа барина. Нүгнээ сахина. Шинийн нэгэн гээд 16 хоног нүгнээ сахина манай тэнд. Нүгнээ сахина гэж маань уншдаг.

Сүмийн дугануудыг дандаа модоор барьсан. Тэгээд тийм амархан алга болсон. Дуганууд нь хоёр давхар. Гурван давхар дуган өр байгаагүй шиг бодогдож байна. Гэгээний дуган төвд маягийн бусад нь хятад маягийн дуганууд байсан. Бор шувуу гэдэг наймаа хоёрыг нь барьсан гэж ярьдаг. 27 алд худаг гаргаад хоёр сүмийг барьсан юм гэнэ лээ. Дүүжин эргүүлгээр авдаг тийм худаг байсан. Хятад мужаанууд Мянган бурханы дуганыг барьсан гэдэг. Чойр дацанд Гүнчэн игчааны дагуу сургалтаа явуулдаг байсан. Адилхан. Ерөөсөө 9 зиндаа байдаг. Хадаг, шидүв, жумбарай, юлжин, дондонжуу, ог, гом, гавданбуу, дом гээд. Есөн жил болоод домын дамжаа барьдаг юм. Хүрээний Дашчоймбэлтэй л харилцаатай байсан. Дашчоймбэлээс л хурал ном, дэг жаягийг дэглэсэн. Дуганууд тус тусдаа жастай. Чойр, Цогчэн, Жүд, Дүйнхор, Ганжуур, Хайлан, Мянган бурханы гэсэн жасууд байсан. Лам нар зүүн баруун хүрээ гэж ангилагдаад суудаг байсан. Зүүн талд байгааг нь Зүүн хүрээ, баруун талд суудгийг нь Баруун хүрээ гэж нэрлэдэг байсан.

Би 1919, 1922 оны үед Дашчоймбэлд ирсэн. Тэгшийн хүрээндээ 10-аад жил суусан.

Хүрээ 30 аймаг

1. Шүтээний аймаг
- 2.Дондовлин аймаг
- 3.Жиддаран аймаг
- 4.Даштойсомлин аймаг
- 5.Дүйнхорын аймаг
- 6.Цэцэн тойны аймаг
- 7.Андуугийн аймаг
- 8.Дашдандарлин аймаг
- 9.Махасамаяагийн аймаг
- 10.Пунцагдэгчинлэн буюу Жасын аймаг
- 11.Номчийн аймаг
- 12.Сангайн аймаг
- 13.Зоогойн аймаг
- 14.Дугарын аймаг
- 15.Чойнхорлин аймаг
- 16.Мэргэн хамбын аймаг
- 17.Бизъяагийн аймаг
- 18.Хүүхэн ноёны аймаг
- 19.Дархан эмчийн аймаг
- 20.Эрхэм тойны аймаг
- 21.Эх дагинын аймаг

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

22. Вангайн аймаг
23. Эрдэнэ хувилгааны аймаг
24. Баргын аймаг
25. Намдоллин аймаг
26. Бандидын аймаг
27. Жамъян сүнгийн аймаг
28. Лам нарын аймаг
29. Мэргэн номун ханы аймаг
30. Өрлүүдийн аймаг

Дашчоймбэл ганц дугантай. Хуучин Дашчоймбэл дацан одоо энэ байгаа дуганаасаа арай том. Гадуураа хоёр давхар цагаан давуун бүрээстэй. Цаад талд нь Бадма Ёгынх гэж алтан дээвэртэй бага дуган байсан. Тэрний цаад талд Гунгаачойлин гэж дуган байсан. Тэрний наад талд алтан дээвэртэй жижиг дуган байсан. Хойшоо энэ өндөр сүм байсан. Тэрний хажууд Идгаа байсан. Дашчоймбэлд тэр үед 5000, 6000 лам хурж байсан байх. Уг нь 7000, 8000 ламтай гэдэг. Настай болсон улс, өвгөн гавж нар хурахгүй. Жилдээ 25-30 гавж гарч байсан байна. Нэг удаад голдуу гурван лам гавжийн дамжаа барьж байж.

Зуны дунд сараас нэг сарын хурал хурна. Дараагаар нь 15 хоногийн хурал хурна. Намар бас нэг сарын, мөн хорь хоногийн хурал хурна. Бас нэг 14,15 хоногийн хурал хурна. Хавар 7 сарын хурал гэж сарын хурал хурна. Тэрнээс гадна хорь хоногийн хурал хурна. Жилдээ 4 удаагийн сарын хурал байна. Өвлийнх нь Жан гүнчэ , хаврынх нь 7 сарын хурал, зуных нь жам ялчэ , намрынх нь жам дончэ гэж хурна. Хорь хоногийн хурлыг нь түгт хорь, торчоот хорь гэж нэрлэдэг. Сайхан Гомбо гэж хурна. Сахиусаа хурж байгаа нь тэр. Хоёр өдөр дуу таслахгүй хурна. Тэгээд гол нь чойр. Бусад цагт хурал хурахгүй, номоо л хэлэлцээд байна. Эрдэмтэй лам нарыг нь тоолоод барахгүй. Дугандаа хурлаа ч хурдаг. Сургалтаа ч явуулдаг байсан. Шавь ч олон, багш ч олон байсан. Багш нарынхаа гэрээр 10-20 уулаа, 4-5-уулаа бараалхана. Одоо тийм номоос бараалхана гэдэг байсан. Домын дамжаа өвлийн дунд сарын хоринд. Тэрнээс наана зун адаг сард лянха дом хурна. Лянха мордоно гэж их сайхан юм болно. Цөмөөрөө цагаан морьтой, цөмөөрөө шономтой. Комбинатын тэрээд гол дээр хурна. Домын өргөө их том. 20-иод ханатай, 40-өөд эсгийгээр бүрдэг байсан. Лхав дом гэдгийг өвлийн их бурханы дүйчэн өдөр, Лам чойнжид дом гэдгийг өвлийн эхэн сарын 25-д хурна. 14-ны жүч гээд дунд сарын 14-нд нэг их дом хурна. Тэгээд 8,9,20-ны дом гээд есөн дом гүйцэж байгаа юм. Тэгээд домын дамжаа. Дом хурсан улсаас асууна. Тэд тусгай ширээн дээр зиндаа зиндаагаараа суучихна. Тэгээд үзсэн номоо шалгуулна. Тэр ч сайн байна. Тэр базаахгүй байна гээд ялгараад ирнэ. Бараг өмнө нь ялгарчихна. Хамгийн тэргүүн нь анги нива, бүр сайчuur нь арван толгой гэнэ. Тэр дотроосоо хамгийн тэргүүн нь анги. Жорвон гэж сайн ч хүн байж болно. Тэр зиндааг ахалсан, зааж зурдаг хүн байдаг. Одоо ч энэ янзаараа. Гэхдээ яж гүйцхэв дээ.

Хийдийн гол шүтээн нь Гомбо, Сэндэм хоёр. Ядам нь Ямандаг.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дашчоймбэлд нэг лам дугандаа үхчихжээ. Баруун өргөө гэж өдөр шөнөгүй хурдаг дуу тасардаггүй газар байсан. Хаагуур гаргах вэ? Яах вэ? гээд Богдод айлтгажээ. Богд зүүн хойд талын хөшгийг сөхөөд хар гэсэн. Тэгсэн тэнд нэг хаалга байсан гэсэн. Өөрсдөө мэддэггүй. Богд л болгоогоод байдаг байсан. Тэгээд одоо миний шавь нар дугандаа үхэхгүй гэсэн юм гэнэ лээ.